

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 132 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолын хоёрдугаар заалтад “Энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, хоёрдугаар хавсралтаар баталсан тарифыг 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Булган мээж” ОНӨХХК (Г.Ганбаатар)-д үүрэг болгосугай” гэснийг “Энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, хоёрдугаар хавсралтаар баталсан тарифыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Булган мээж” ОНӨХХК (Г.Ганбаатар)-д үүрэг болгосугай” гэж, дөрөвдүгээр заалтад “Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн “Тариф батлах тухай” 459 дүгээр тогтоолыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай” гэснийг “Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн “Тариф батлах тухай” 459 дүгээр тогтоолыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ, тарифын газар (Б.Эрдэнэбулган)-г даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ